

## СУЛИНХЭЭРИЙН БУС БА ХУТАГ УУЛЫН БЛОКИЙН МЕТАЛЛОГЕНИЙ АСУУДАЛД

Л.ДАЛАЙ<sup>1</sup>, Б.БААСАН<sup>1</sup>, Б.АЛТАНГЭРЭЛ<sup>1</sup>, Ж.БЯМБА<sup>2</sup>

<sup>1</sup>-Гео-эрэл ХХК, <sup>2</sup>-Монгол Улсын Их Сургууль

### Судлагдсан байдал

Сулихээрийн бус нь нилээд нийлмэл тогтоцтой учир судлаачдын дунд түүний хөгжлийг өөр өөрөөр тайлбарлаж иржээ. Тухайлбал О.Д.Суэтенко [1] уг бүсийг Өвөр Монголын атираат бүсэд хамааруулж энд охиолитийн бүрэн эвшил байхгүйг тэмдэглэсэн байна. А.Б.Дергунов, Н.С.Зайцев, нар [2] уг бүсийг хожуу палеозой+түрүү мезозойн атираат структуур гэж үзсэн бол Ж.Бямба [3] түүнийг рифтийн структуур хэмээн тодорхойлжээ. Мөн С.В.Руженцев нар [4] Сулихээрийн бүсийг рифтингээр үүссэн далайн структуур гэж үзсэн байна.


Металлогенийн хувьд энэ дүүрэгт В.А.Кузнецов Сулихээрийн бүсийг Төв Азийн мөнгөн усны металлогенийн их бүслүүр гэж ялгасан бол А.А.Оболенский [9] энд Өмнөд Тотошаны мөнгөн усны бүсийг ялгажээ. Г.Дэжидмаа нарын [8] зохиосон 1:1000000 масштабтай ашигт малтмалын зурагт уг дүүргийг Өмнөд Монголын металлогенийн их мужид хамааруулж Хутаг уул, Халzan уулын металлогенийн бүсүүдийг ялгасан байна.

Сүүлийн үед энэ дүүрэгт Б.Алтангэрэл, Ж.Өлзийбаяр, Л.Далай, Б.Баасан, Я.Даваадорж, Г.Бөмберөө нар [5, 6, 7] геологийн эрэл-зураглалын ажлыг гүйцэтгэсэн нь Сулихээрийн бус ба Хутаг уулын блокийн геологи ба металлогенийн талаар цоо шинэ мэдээлэлүүд цугларч байна.

### Структуур-металлогенийн дүүрэгчлэл

Дээрх судалгааны материалыг нэгтгэж үзвэл энэ дүүрэгт Хутаг уулын блок (супертеррейн), Сулихээрийн бус (террейн) гэсэн хоёр томоохон структуурийн нэгжийг ялгаж болно.

Хутаг уулын блок нь Өмнөд Монголын эртний цулдалын урд зах бөгөөд судалгаа явагдсан талбайн хэмжээнд түүнийг дотор нь Баяновоогийн цухуйгдал, Жирэмийн рифт, Далан Ухаагийн өргөгдөл гэсэн структуурийн нэгжүүдэд хувааж болно. Ялгаж байгаа структуурийн нэгж болгон металлогенийн өөрийн гэсэн онцлогтой (1-р зураг).



Зураг 1. Сүтинхээрийн бүс, Баяновогийн шүүлтийн структур-металлогений будуувч

1-4-Сүтинхээрийн бүс: 1-Номт уулын хотгор ба Хэцүү уулын бүрхээс /покров/, 2-Таванхарын бүрхээ, 3-гипербазит, 4-Даргинатын блок, 5-6-Хутаг уулын блок: 5-Баяновогийн шүүхгэлдэл, 6-Жирэмийн рифт, 7-Далан ухаагийн өргөгдөл, 8-мезокайнозойн хутаас, 9-11-Металлогенийн ачаалал: Ашигт малтмалын ширэл: а-алтны, б-хромитын, в-алт-мөнгөн усны, г-холимог металлын скарн, 10-геохимийн сарнины хүрээ, 11-хагарал /агтол структурийн нэгжийг тусгаарлах байгаа, б-бусад/. Тоогоор ашигт малтмалын нэрийг тэмдэглэв: 1-9-алтны: 1-Далан ухаагийн, 2-Жирэмийн, 3-Хөтөл толгойн, 4-Баян овоогийн, 5-Шарга толгойн, 6-Цуваагийн, 7-Баруун ширүүний хүдлийн, 8-Лартын нурууны, 9-Таратын овоогийн, 10-Онцой толгойн, 11-Зост толгойн, 12-13-алт-мөнгөн усны, 121-Таван хар толгойн, 13-Ханти овоогийн

Баяновоогийн цухуйгдал нь Өмнөд талаараа Номт уулын хагарлаар Сулинхээрийн бүсээс хязгаарлагддаг ба баруун ба баруун-хойд талаараа Жирэмийн рифтоген хотгороос мөн хагарлаар тусгаарлагдана. Блокийн хэмжээнд доод протерозойн Хутаг уул комплексийн талстат занар, боржин-гнейс, гантиг, мигматит нилээд өргөн тархсан бөгөөд мезо-неопротерозойн деструкцийн явцад түрсэн габбро-диорит, боржин-диорит боржингийн интрузийн биетүүдээр түрэгдсэн байна. Хожуу пермийн эхэн үед субдукцийн явцад үүссэн Өвгөн толгой формаацын тасралтгүй ялгарсан вулканиттай нэгэн эвшлийг үүсгэдэг Баяново хэмээх шохойлог-шултлэг интрузийн бүрдэл түрсэн ажээ. Энэхүү Баяновоогийн цухуйгдалын хэмжээнд нь дунд-хожуу юрагийн цаг үед нийт Хутаг уулын блокийн нэгэн адил деструкц явагдаж шултлэг вулканит бялхаж, мөн шултлэг интруз түрэн бүдүүн хэмхдэст молассаар дүүрсэн рифтийн давхцмал хотгорууд хэлбэржсэн байна.

Баяновоогийн цухуйгдлын хэмжээнд Хутаг уул комплекстэй холбоотой бага сульфидтэй кварцын биетүүд холбоотой алтны хүдэржилт, эрдэсжсэн цэгүүд болон шлихийн сарнилийн хүрээ тогтоогджээ.

Мөн Хутаг уул комплексийн хэмжээнд илэрсэн хүчиллэг ба дундлаг найрлагатай дэл судлын чuluулагтай холбоотой Мөнхийн толгодын, Шарын хоолойн гидротермаль гаралтай мөн алтны 0.05г/т агуулгатай хүдэржилт судлагдсан байна. Түүнээс гадна Цохиот, Хүнновоот толгойн өндөр температурын алт-сульфидийн хүдэржилт, түүнийг дагаад шлихийн сарнилийн хүрээ тогтоогджээ.

Хутаг уул комплексийн карбонат зузаалагтай холбоотой Баруун Шируүний. Худагийн дүүрэг мышьяк, сурьма дагалдсан Хартугалга-цайрын хүдэржилттэй метасоматит гаралтай шохойлог скарн илэрсэн байна. Эдгээр скарнд 0.005 г/т агуулгатай алтны хүдэржилт судлагдсан байна.

Жирэмийн рифтоген хотгор нь зүүн-урд талаараа Хармортын хагарлаар үүссэн түрүү мезозойн рифтоген хотгороор Баяновоогийн цухуйгдлаас тусгаарлагдана. Жирэмийн рифт нь түрүү карбонд Сулинхээрийн далайн савыг үүсэхэд нээгдсэн байна. Уг рифтийн зүсэлтийн доод талд түрүү карбоны настай Жирэм формаац хэмээх конгломерат, гравелит, алевролит, аргиллит, элсжин ажиглагдах бөгөөд зүсэлтийн дээд талд доод-дунд пермийн Өвгөнтолгой формаацын тунамал-вулканоген бүрдэл зонхилно. Энэхүү рифтийг хаагдаад дээд

пермийн настай Луугийн гол формаацад хамааруулсан флишлэг түрбидит эх газрын хотгорын хэмжээнд хэлбэржсэн байна. Жирэмийн рифтогенийн хотгорын хэмжээнд хожуу триас-түрүү юрагийн үед Халзан уул бүрдэлийн лейкоборжингийн биетүүд түрсэн байна.

Металлогенийн хувьд Баруун сүүж ба Жирэм уулын дүүрэгт кварц-сульфидийн төрлийн алтны хүдэржилт болон Халзан уул интрузийн бүрдэлтэй холбоотой шеелит, вольфрамит, касситеритийн хүрээ илэрсэн нь энд вольфрам, цагаантугалганы хүдэржилт тус тус тогтоогдсон байна. Мөн интрузийн Хатанбулаг бүрдэлтэй холбоотой цагаан алтны шлихийн сарнилийн хүрээ илэрчээ.

Далан Ухаагийн өргөгдол доод протерозойн талстат занар, кварцит, гантигаас зонхилон тогтоно. Энэхүү өргөгдлийн хэмжээнд дунд-хожуу девоны Хатанбулгийн хэмээх интруз бүрдлийн габбро, габбро-диоритийн биетүүд түрсэн байна. Уг өргөгдлийн хэмжээнд доод-дунд пермийн тасралтгүй ялгарсан вулканитын найрлагатай Өвгөнтолгой формаацын чулуулаг өргөн тархжээ.

Далан Ухаагийн өргөгдлийн хэмжээнд төмөрт кварциттай холбоотой Далан Ухаагийн алтны хүдэржилт, интрузийн Хатанбулаг бүрдэлтэй холбоотой алт, цагаан алтны шлихийн хүрээ судлагджээ.

*Сулинхээрийн бүс* нь Монгол, Хятадын хилийг дамнан байрласан түрүү карбонаас пермийн эцэс хүртэл хэлбэржсэн аккрецийн террейн юм. Энэхүү аккрецийн террейний хэмжээнд Номт уулын хотгор, Хэцүү уулын ба Таван харын бүрхээсүүд (покров) болон Даргиатын блок гэсэн структуурний нэгжүүдийг ялгаж байна.

Номт уулын хотгор нь Баяновоогийн цухуйгдлаас Номтын хагарлаар тусгаарлагдах бөгөөд уг цухуйгдлын урд захыг элсжин байрласан өргөрөгийн чиглэлтэй ерөнхийдөө урагшаа уналтай ялтас (хуудас) маягийн структуур юм. Уг хотгорыг Номт формаацад хамааруулсан полимикт найрлагатай элсжин, алевролит, аргиллит зэрэг терриген найрлагатай градацын үелэл бүхий түрбидитээс тогтох бөгөөд хааяа шохойжин, вулканитийн үе дайралдана.

Геотектоникийн хувьд энэхүү хотгорыг үүсгэж байгаа Номт формаац нь эх газрын Нууын өврийн хотгорын хэмжээнд үүссэн байж болох юм.

Металлогенийн хувьд Номт формаацын хэмжээнд илэрсэн кварцын эптермаль судалтай холбоотой алт-сурьмагийн илрэл болон хагарал, бутралын бүсийг даган тогтоогдсон алт-мөнгөн усны хүдэржилтийг дурьдаж болно.

Хэцүү уулын бүрхээс нь Хангийн овоо формаац дээр хурдас хуримтлалын тасалдалтайгаар байрлах Агуй уул формаацын шохойжин, Хэцүү уул формаацын вулканитаас бүрэлдэнэ. Эдгээр нь өргөрөгийн дагуу сунаж тогтсон блокуудад хуваагдана. Ерөнхийдөө хойноосоо урагшаа уналтай ялтаслаг (хуудсархаг) структуурнийг үүсгэж байгаа гол шалтгаан нь Таван харын бүрхээс сүбдүүкүүж чадахгүй шантаглахад Хэцүү уулын бүрхээс гипербазит дээгүүр тохрон бүрхээс, клип маягийн структуурнийг үүсгэсэн гэж үзэж болно.

Хэцүү уулын бүрхээсийн хэмжээнд бага температурын эптермаль гаралтай кварцын судалтай холбоотой Хөтөл, толгойн алт-сурьма-мышъякийн болон гидротермаль гаралтай судлын төрлийн алт-мөнгөн усны хүдэржилтүүд тогтоогджээ.

Далайн плитийн меланократын суурийн гаралтай байж болох гипербазит ба түүний өгөршилийн бүстэй холбоотой алт, хромит, магнезит, никелийн хүдэржилт Баруун сүүжийн хяр, Зост толгой, Онцгой толгой, Цахиурт зэрэг газруудад илэрчээ. Онцгой толгойн мөнгөн ус-алтны илрэл нь Хэцүү уул формаацын конгломерат, гравеллит, дунд хүчтэй лиственитжсэн апосерпентенитийн биетүүдтэй холбоотой үүссэн бөгөөд алтны агуулга 0.02-0.005 г/т, хромын агуулга, 0.02%, мөнгөн усных 0.02% тогтоогдсон байна. Цахиур толгойн алт-сурьма-мышъякийн илрэл нь мөн Хэцүү уул формаацын тектоникийн бусанд өртөж брекчлэгдсэн риолиттой холбоотой үүссэн 3 км орчим ургэлжлэх хальцедоны төрлийн кварцын судлын бусанд илэрчээ. Геохимиин сорьцлолтоор алт -0.08 г/т, сурьма 0.029%, мышъяк 0.026% тус тус тодорхойлогддээ.

Таван харын бүрхээс бол голдуу шүлтлэгдүү найрлагатай андезит, андезит-дацит-риолитийн Таван хар формаацын вулканит болон Хар эрдэнэ формаацын терриген хурдсаас тогтоно.

Эдгээр вулканоген-терриген бүрдэл петрохимиийн ба литологийн найрлагыг аваад үзвэл нилээд зузаарсан далайн төрлийн царцасын хэмжээнд үүссэн болтой юм.

Энд мөнгөн ус-алтны хүдэржилт зонхилон илэрчээ.

Даргиатын блок бол Сулинхээрийн бүсэнд байрласан мезо-неопротерозойн настай структуур юм. Энэ блок нь талстлаг занар, ногоон занар, амфиболит, кварцит зэрэг бүс нутгийн метаморфизмын эпидот-амфиболитийн фаацын хувиралд өртсөн чулуулгаас тогтоно.

Даргиатын блокийн хэмжээнд Төмөртийн хэсгийн төмөрт кварциттай холбоотой мэшил маягийн стратиграфмын төрлийн 0.5-0.9 г/т агуулгатай алтны хүдэржилт, Шарга дэл толгой ба ижил нэртэй хөндийн дүүргүүдэд илэрсэн. Мөн хагарлын бүс дагасан бирбиритийн бүстэй холбоотой Цувраа гурван толгойн алтны илрэл, эрдэсжсэн цэг болон зэс-цайрын геохимийн гажилууд тогтоогдсон болно. Түүнээс гадна кварц-сульфидийн төрлийн алт, холимог металлын болон цагаантугалганы хүдэржилт Улаандэлийн сайрын дүүрэгт судлагдсан байна.

### Металлогенийн үе шат

Судалгаанд хамрагдсан талбайн хэмжээнд палеопротерозойн, мезо-неопротерозойн, дунд-дээд девоны, карбон-түрүү пермийн, хожуу перм-түрүү триасын, хожуу триас-түрүү юрагийн гэсэн металлогенийн зургаан үе шатыг хувааж болох юм.

Палеопротерозойн металлогенийн үе шатанд өндөр температурын кварцитай холбоотой алтны хүдэржилт болон мезо-неопротерозойн үе шатанд шохойлог скарнтай холбоотой алт-полиметаллын хүдэржилт, хийгээд Далангийн Ухаагийн өргөгдлийн ба Даргиатын блокийн төмөрт кварциттай холбоотой алтны хүдэржилт тус тус үүссэн байна.

Дараачийн металлогенийн үе шат болох девонд суурилаг интруз чулуулагтай холбоотой үүссэн цагаан алт, алтны хүдэржилтийг дурьдаж болно.

Нийзэд сонирхолтой гэж үзэж болох карбон-түрүү пермийн металлогенийн чухал үе шатанд гипербазиттай холбоотой хром, алт, магнезитийн хүдэржилт судлагдсан болно.

Сулинхээрийн бүсийн металлогенийн нүүр царайг тодорхойлж байгаа өөр нэгэн гол үе шат бол хожуу перм-түрүү триасын алт-мөнгөн усны, алт-сурьма-мышьякийн хүдэржилт юм. Эдгээрээс хамгийн сонирхолтой нь Хөтөл толгойн, Баруун сүүжийн толгодын ба Хангивоосгийн илрэлүүд юм.

Сулихээрийн бүсийг хаагдсан дараах эх газрын хөгжлийн үе шат болох хожуу триас-туруү юрад Халzan уул интрузийн бүрдэлтэй холбоотой цагаантугалга-вольфрамын ба алтны худэржилт үүссэн байна.

Нийтэд нь дүгнэж үзвэл судалгаанд хамрагдсан талбайн хойд талыг эзлэх Хутаг уулын блокийн өмнөд хэсэг нь металлогенийн хувьд алт, вольфрам, цагаантугалга, полиметаллын төрөлжилттэй байхад талбайн төвийн ба өмнөд хэсгийг хамарсан Сулихээрийн бүс нь алт, мөнгөн ус, хромитийн төрөлжилттэй болох нь харагдаж байна.

### Зохиол

1. Суетенко О.Д., 1971, Тектоника палеозой юго-восточной Монголии. Автореферат канд.диссертации. Москва, 29 с.

2. Дергунев А.Б., Зайцев Н.С., Моссаковский А.А., Перфильев А.С., 1971 Герциниды Монголии и проблема Палеотетиса Проблемы теоретической региональной тектоники. Москва.

3. Бямба Ж., 1990, Основные этапы тектонического развития территории Монголии Изв. ВУЗ, Геология и геофизика, стр. 29-36

4. Руженцев С.В., Постолов И.И., Бадарч Г., 1992, Офиолитовые сутуры Внутренней Монголии. ДАН СССР, т.322, №5, стр.953-958

5. Дагва-Очир Я., Сэргиннамжил., 2001, Дорноговь аймгийн Өргөн, Сайхандулаан, Мандах, Эрдэнэ, Хөвсгөл, Хатанбулаг, Улаанбадрах сумдын нутагт 1991-1994 онуудад Зүүнбаянгийн III ангийн гүйцэтгэсэн 1:200000 геологийн бүлэгчилсэн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан, УБ, ГМТ

6. Алтангэрэл Б., Дамдинжав Б., Жамсранжав Ц., Чулун Д., Батжаргал Н., 1998, Зүүнбаруун Тогоо уулын районд 1996-1997 онд хийсэн 1:50000-ны харьцалтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан. УБ, ГМТ

7. Алтангэрэл Б., Баасан Б., Далай Л., 2001, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг Сулихээрийн талбайд 1999-2001 онд гүйцэтгэсэн 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан. УБ, ГМТ

8. Дэжидмаа Г. нар, 2001, Монгол Улсын ашигт малтмалын (төмөрлөг, үйлдвэрлэл-техникийн түүхий эд) 1:1000000 масштабын зураг, УБ, ГМТ.

9. Оболенский А.А., 1985, Металлогения на ртуть МНР. УБ.